



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: 1.7%, 2023 онд: 4.9%
 Инфляци: 2022 онд: 14.7%, 2023 онд: 11.6%

Урсгал тэнцэл: 2022 онд: -19.5%, 2023 онд: -16.8%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2022 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>

ДНБ-ий өсөлт: 2022 онд: 2.5%
 Инфляци: 2022 онд: 14.8%


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: -20.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 9-р сарын байдлаар 962.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 19.1 хувиар өссөн бол, зарлага 14 хувиар өсч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 962.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 24.7 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 71.40 төгрөгөөр өсчээ.

Есдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 408 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 71.40 төгрөгөөр өсөж 3257.10 төгрөг болов. 9-р сард гадаад валютын нөөц 2.7 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 3.67 хувиар өсөж оны эхнээс 35.99 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 33.16 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцын түвшин 13.8%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 9-р сарын байдлаар өмнөх сараас 0.2 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар, оны эхнээс 9.5 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 17.1 хувь (мах, махан бүтээгдэхүүн 2.2 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 25.9 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 17.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 12.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 20.3 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 2405 сая.ам долларын ашигтай гарав.

2022 оны есдүгээр сард нийт барааны эргэлт 15.118 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 31.1 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 36.8 хувь, импорт өмнөх оны мөн үеэс 23.9 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 2405 сая ам.долларын ашигтай гарав.



9-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: www.1212.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 9-р сард өмнөх сараас 0.9 хувиар нэмэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 13.8 хувиар тус тус өсөж 22.9 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 2565 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 29.2 хувиар өсөж, өнгөрсөн оны мөн үеэс 13.6 хувиар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 11.1% байна.

САРЫН ОНЦЛОХ

МОНГОЛБАНК: БОДЛОГЫН ХҮҮГ ХОЁР НЭГЖ ХУВИАР НЭМЭГДҮҮЛЖ, 12 ХУВЬ БОЛГОВ.

- Монголбанк мөнгөний бодлогын хүүг хоёр нэгж хувиар нэмэгдүүлж, 12 хувь болгохоор шийдвэрлэв. Бодлогын хүүгийн коридорыг бодлогын хүүгээс +2, -2 нэгж хувь болгож, өргөтгөхөөр болсон. Гадаад валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор банкуудын 360 хоног ба түүнээс дээш хугацаагаар гадаад зах зээлээс татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох гэсэн багц шийдвэр гаргав. Дотоод эдийн засгийн хувьд, энэ оны эхний хагас жилд хөл хорионы дэглэм суларч, дотоод эдийн засаг эрчимжсэн. Ингэснээр эдийн засаг 1.9 хувиар тэлээд байна. Тээвэр, уул уурхай, барилгын салбараас бусад бүх салбарт эдийн засаг өсөлттэй байгаа. Тиймээс энэ оны эдийн засгийн суурь төсөөллийг гурван хувьд хүргэхээр болсон.

АХБ: МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ 0.6 ХУВИАР БУУРУУЛАН ТООЦОВ.

- АХБ-аас Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн өмнөх төсөөлөл 2.3 хувийг бууруулж 1.7 хувьд тооцов. Мөн ирэх оны 5.6 хувийн өсөлтийг бууруулж 4.9 хувь болгосон талаар тус банкнаас эрхлэн гаргадаг эдийн засгийн төлөвийн шинэчилсэн ээлжит тайланд дурджээ. Гэхдээ гадаад орчны эрсдэл буурч, БНХАУ-тай хиллэдэг худалдааны гол боомтууд дахь хил, гаалийн хориг, хязгаарлалт суларч, нээлттэй болон шийдвэрлэгдэнэ гэсэн эерэг хүлээлт байна. Үүнд үндэслэвэл Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2023 онд нэмэгдэх боломжтой. Инфляц болон урсгал дансны алдагдал өмнөх төсөөллөөс давж өсөх төлөвтэй байна. Энэ нь богино хугацаанд макро эдийн засгийн тэнцвэрийг хангах бодлогын сорилт, шаардлагыг бий болгож байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 9-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 9-р сар 2022 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn